



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан зарим үйл ажиллагаа болон тус хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох төсвийг зарцуулах эрх олгосон байдал



**МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ
ХУУЛИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТАЛСАН ЗАРИМ
ҮЙЛ АЖИЛЛАГАА ХОЛБОГДОХ ХУУЛЬ
ТОГТООМЖИД НИЙЦЭЭГҮЙ БАЙНА**



АГУУЛГА

Үндэсний аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт	2
Тайланг бэлтгэсэн:	Аудит хийх үндэслэл	3
МУЕА-ын зөвлөх А.Энхбат	Аудитын нэр	3
Газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням	Аудитын код	3
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Энхбаатар	Аудитын зорилт	3
Ахлах аудитор Д.Отгонбаяр	Хамрах хүрээ	3
Аудитор М.Гүнжмаа	Арга зүй	3
	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
	Аудит хийсэн хугацаа, багийн бүрэлдэхүүн	4
	Үндсэн мэдээлэл	4-5
	Нэг. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан үйл ажиллагааны зарим эрх зүйн зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна	6-9
	Хоёр. Улсын Их Хурал, ТБХ-ны хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах, ашиглах журмын хэрэгжилт хангалтгүй байна.....	9-10
	Гурав. Төсвийн Ерөнхийлөн Захирагч хооронд төсөв зарцуулах эрх шилжүүлэх хууль эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй байжээ	11-12
	Дүгнэлт	13
	Зөвлөмж	14
	Хавсралт	15-18
	Холбогдох байгууллагын санал	19
	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	20
Уг тайланг YAГ-ын Вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn		
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 261805 дугаарын утас, факсаар харилцана уу.		
Хаяг:		
Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3 Засгийн газрын IY байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс		
2017 оны 08 дугаар сарын 15-ны өдөр		



ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АН	Ардчилсан нам
БСШУ	Боловсрол соёл, шинжлэх ухааны
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЗТБХБ	Зам тээвэр барилга хот байгуулалт
МАН	Монгол Ардын нам
МУИХЧХДТХ	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль
МУИХТХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НА	Нийцлийн аудит
НАГ	Нийцлийн аудитын газар
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын тамгын газар
ТБХ	Төсвийн Байнгын Хороо
ТБУСТХ	Төсвийн Байгууллагын Удирдлага Санхүүжилтийн Тухай Хууль
ТЕЗ	Төсвийн Ерөнхийлөн Захирагч
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар



Аудит хийх үндэслэл

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.8 дахь заалтуудыг үндэслэн Авлигатай тэмцэх газрын 2017 оны 01/1876 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу УИХ-ын ТБХ-ны 2017 оны 9/4456 тоот албан бичгээр ирүүлсэн зөвшөөрөл мөн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд аудит хийж гүйцэтгэлээ.

1. Аудитын нэр:

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан зарим үйл ажиллагаа болон тус хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох төсвийг зарцуулах эрх олгосон байдал.

2. Аудитын код:

ҮАГ-ГАГ/2017/05-НА

3. Аудитын зорилт:

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан зарим үйл ажиллагаа болон тус хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний зарим төсвийг зарцуулах эрх олгосон байдалд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дараах дэд зорилтуудын хүрээнд аудит хийхээр төлөвлөсөн. Үүнд:

- Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг ТБХ-ны хуралдаан болон УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцсэн, санал хураалт явуулсан, баталсан үйл явцад холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлсэн эсэх;
- Монгол Улсын 2012 оны төсвийг хэлэлцэн баталсан ТБХ-ны хуралдаанууд болон нэгдсэн чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, хадгалах, ашиглах үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зарим төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулах эрх олгосон эсэх;

4. Хамрах хүрээ:

Тухайн аудитад Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан зарим үйл ажиллагаа болон тус хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох төсвийг зарцуулах эрх олгосон байдалд УИХ-ын Тамгын газар, Төсвийн болон бусад байнгын хороод, Түр хороод, нам, эвслийн бүлгүүд, холбогдох ажлын хэсгүүд, Сангийн яам болон холбогдох бусад яамд, НЗДТГ, зарим дүүргийг хамрууллаа.

5. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 4000, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан архивын баримт материалтай танилцах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийж, асуулга, лавлагаа, тайлбар, мэдээлэл гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, хуулийн хувийн хэрэг болон архивын баримтыг судлах зэрэг аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийж зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалган баталгаажуулав.



5. Аудит хийхэд ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль /тухайн үед мөрдөгдөж байсан/;
- Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хууль /тухайн үед мөрдөгдөж байсан/;
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль,
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- УИХ-ын 2006 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм”;
- Монгол Улсын Сангийн сайдын 2010 оны 135 дугаар тушаалаар баталсан “Улсын болон орон нутгийн төсөв тэдгээртэй адилтгах хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, барилга байгууламж, их завсар, худалдан авах тоног төхөөрөмжийн хөрөнгийг төлөвлөх, гүйцэтгэл гаргах, санхүүжүүлэх, хяналт тавих журам”;
- Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний төвийн Зөвлөлийн 2002 оны 17 дугаар тогтоолоор баталсан Баримт бичгийн MNS 5141:2002 стандарт;
- Архивын Ерөнхий газрын даргын 2009 оны 68 дугаар тушаалаар баталсан “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”;
- Холбогдох бусад хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, стандарт.

7. Аудит хийсэн хугацаа, багийн бүрэлдэхүүн:

Аудитын ажлын явцыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Давааням хянан удирдаж, МУЕА-ын зөвлөх А.Энхбат аудитын стандарт, журмын дагуу чанарын хяналтыг хэрэгжүүлэн, Нийцлийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр ахлан оролцож, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Энхбаатар, Гүйцэтгэлийн аудитын газрын аудитор М.Гүнжмаа нар хариуцан 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатыг хийж гүйцэтгэлээ.

8. Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын төсөвт 2012 оны төсвийн жилд төвлөрүүлэх орлого, зарцуулах зарлагын хэмжээ, орлого төвлөрүүлэх байгууллага, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс татан төвлөрүүлэх орлогын хэмжээг тогтоох, Төсвийн ерөнхийлөн захирагчид төсөв зарцуулах эрх олгох, Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах хөрөнгийн хэмжээтэй холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг УИХ, Байнгын болон дэд хороо, намын бүлгүүд МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9 дэх хэсэгт заасны дагуу 4 үе шаттайгаар хэлэлцэн 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан байна.

Тус хуулийн төслийн эцсийн найруулгыг 2011 оны 12 дугаар сарын 06-ны өдөр уншиж, үг хэллэг, найруулга, техникийн шинжтэй засваруудыг хийж, төслийг 2011 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ёсчилсон байна.

Нэгдсэн төсвийн тухай болон Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хуулиуд 2011-2012 онуудад хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бөгөөд УИХ, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд УИХ-ын Тамгын Газрын ЕНБД-ын 2002 оны 293 дугаар захирамжаар баталсан “Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын хуралдааны явцын



тэмдэглэл хөтлөх, соронзон бичлэг хийх, CD-д буулгах, түүнийг хадгалах, ашиглах журам”, мөн 2003 оны 232 дугаар захирамжаар баталсан “Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар”, “Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын архивын ажлын заавар”-уудыг мөрдөн ажиллаж байжээ.

УИХ-ын 2006 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дүрэм”-д заасны дагуу УИХ-ын Тамгын газар нь УИХ, Байнгын болон Дэд, Түр хороодын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, тэдгээрийг ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй байна.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн батлах зарим үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцсэн эсэх, тухайн үйл ажиллагаанд оролцогчдын эрх үүргийн талаар болон төсвийн захирагчид төсөв зарцуулах эрх олгож, хяналт тавих үйл ажиллагаа холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар хийсэн аудитын дүнг дараах 3 бүлэгт тусгалаа.



1. МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ЗАРИМ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

1.1. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн нэг болон хоёр дахь хэлэлцүүлгийн талаар:

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг Засгийн газраас 2011 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, 2011 оны 10-р сарын 26-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.1¹-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд 2012 оны төсвийн төслийн талаар илтгэл тавьж, нэг дэх хэлэлцүүлэгт оролцсон гишүүд бүрэн эрхийн хүрээнд асуулт асууж, үг хэлсний дараа хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр гишүүдийн олонхийн саналаар Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, намын бүлгүүдэд шилжүүлсэн байна.

МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.2²-д заасны дагуу Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороод 2011 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуралдаанаараа тус тус хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, ТБХ-ны хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахаар санал, дүгнэлт болон хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх дараах тооны зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг тус тус хүргүүлсэн байна. Үүнд:

№	Байнгын болон дэд хороо	Санал	Үүнээс:	
			Дэмжигдсэн	Дэмжигдээгүй
1.	Хууль зүйн байнгын хороо	6	4	2
2.	Эдийн засгийн байнгын хороо	12	12	-
3.	Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо	48	48	-
4.	Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо	5	5	-
5.	Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо	8	8	-
6.	Төрийн байгуулалтын байнгын хороо	2	2	-
Нийт		94	84	10

ТБХ-ны 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, намын бүлгүүдийн санал, дүгнэлтийг хэлэлцэхдээ МАН, АН-ын бүлгүүдийн “УИХ дахь МАН, АН-ын бүлгүүдийн хамтарсан санал дэмжигдсэн тохиолдолд УИХ-ын Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороон дээр гаргасан хөрөнгө оруулалтын зардал нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй саналуудыг санал хураалгалгүйгээр татуулах” гэсэн горимын саналыг гишүүдийн олонхи дэмжин шийдвэрлэжээ.

Тус өдөр болсон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар дээрх саналыг дэмжин шийдвэрлэсэн нь МУИХТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1³ дэх хэсэгт заасан УИХ-ын гишүүний бүрэн эрхийг зөрчих эрсдэлийг үүсгэсэн байна.

¹ 25.9.1. нэг дэх хэлэлцүүлэгт Ерөнхий сайд төсвийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд илтгэл тавина.

² 25.9.2.хоёр дахь хэлэлцүүлгээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж гарсан санал, дүгнэлтийг томъёолон ТБХ-нд өгөх...

³ 7.1. Гишүүн дараахь бүрэн эрхтэй: 7.1.10.зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, санал хураалгах;



Гүүнчлэн МАН, АН-ын намын бүлгүүдийн санал нэгдэж оруулсан дээрх горимын саналыг ТБХ-ны хуралдаанаар хэлэлцэхдээ хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээг нэг бүрчлэн хэлэлцэж санал хураалт явуулалгүйгээр төсөвт өртгийг багцлан 206,731.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэх зарчмын зөрүүтэй саналаар хуралдаанд танилцуулж, гишүүдийн олонхи дэмжиж шийдвэрлэсэн нь МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.2⁴ дахь заалт, 25.13⁵ дахь хэсэгт нийцээгүй байна.

ТБХ-ны 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн тус хуралдаан 21 цаг 00 минутаас эхэлж 23 цаг 10 минутад өндөрлөсөн байх бөгөөд хуулийн төслийг УИХ-ын нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулахаар санал, дүгнэлтийг 30 минутын дотор боловсруулахдаа тус хуралдаанаар дэмжигдсэн дээрх 206,731.5 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх саналын дүнг өөрчлөн 7,450.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 214,181.5 сая төгрөг болгосон нь ТБХ-ны хуралдааны 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар хуралдааны тэмдэглэл, ТБХ-ны даргын УИХ-ын нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт танилцуулсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол зэргээс нотлогдож байна.

Мөн УИХ-ын нэгдсэн хуралдаан тус өдрийн 23 цаг 45 минутад эхлэн төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийхэд МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.2⁶ дэх хэсэгт заасны дагуу ТБХ санал дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулахдаа хөрөнгө оруулалтын төсвийн өртгийг 214,181.5 сая төгрөг болгон нэмэгдүүлж өөрчилснийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар дэмжсэн байна.

Намын бүлгүүдийн хуралдааны тэмдэглэл, хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалт болон холбогдох материалууд УИХ-ын Тамгын газарт архивлагдаагүй, тус хуулийн хувийн хэргийн архивын баримт бичгийн бүрдэл дутуу зэргээс шалтгаалан “МУ-ын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын төслийг ямар нэгж, албан тушаалтан хариуцан боловсруулж, өөрчлөлтийг хийсэн нь нотлогдохгүй байх тул аудитын явцад нягтлан шалгах, дүгнэх боломжгүй байна.

1.2. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийн гурав болон дөрөв дэх хэлэлцүүлэг:

УИХ-ын ТБХ-ны болон УИХ-ын нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан “Хөрөнгө оруулалтын төслийн нэрийг өөрчлөх болон санхүүжилтийн дүнд зохицуулалт хийх санал”-уудыг төсвийн төсөлд нэмж тусган, нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлэгт оруулахдаа УИХ-ын Тамгын газрын холбогдох албан хаагчид ажлын байрны чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.3⁷ дахь заалтыг зөрчиж, тус саналд тусгагдсан зарим төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг нэмсэн, төсөвт өртгийг хассан, мөн зарим төсөл, арга хэмжээг бүхэлд нь хассан зөрчил аудитын явцад тогтоогдож байна. Тус зөрчлийн мэдээллийг хүснэгтэд харуулав.

⁴ 25.9.2.хоёр дахь хэлэлцүүлгээр бүх Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төсвийн төслийг эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж гарсан санал, дүгнэлтийг томъёолон ТБХ-нд өгөх ба тус хороо эдгээр болон гишүүдийн гаргасан саналыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд нэгдсэн хуралдаан санал тус бүрээр ил санал хураалт явуулна;

⁵ 25.13.ТБХ- энэ хуулийн 25.12-т заасан болон өөрийнхөө Байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан Ерөнхийлөгч, Төрийн аудитын төв байгууллага, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхийн дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж нэгдсэн хуралдаанд оруулна.

⁶ 25.9.2. “хоёр дахь хэлэлцүүлгээр ...тус хороо эдгээр болон гишүүдийн гаргасан саналыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд нэгдсэн хуралдаан санал тус бүрээр ил санал хураалт явуулна;”

⁷ 25.9.3.гурав дахь хэлэлцүүлгээр ТБХ- нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхийн дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамтаар нэгдсэн хуралдаанд оруулна;



	Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлэгт дэмжигдсэн саналын агуулга	Нэгдсэн хуралдааны 3 дахь хэлэлцүүлэгт оруулахдаа төсвийн төсөлд нэмж тусгасан агуулга
	1.Төсөвт өртгийг нэмсэн:	
1.	Орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Сэлэнгэ/ -1.000.0 сая төгрөг гэж өөрчлөх;	Орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Сэлэнгэ/ - 3.000.0 сая төгрөг батлагдсан.
2.	Аймгийн музей, эмнэлгийн түргэн тусламжийн автомашин /Дорнод, Чулуунхороот, Халхгол, Булган, Матад/ -100.0 сая төгрөг гэж өөрчлөх	Аймгийн музей, эмнэлгийн түргэн тусламжийн автомашин /Дорнод, Чулуунхороот, Халхгол, Булган, Матад/ - 125.0 сая төгрөг батлагдсан.
3.	Төслийн хавсралтын XXI.2.1.12-ын “1800.0” гэснийг “1.000.0” гэж өөрчлөх;	Төсвийн хавсралтын XXI.2.1.12-ын “ 1.200.0 ” сая гэж батлагдсан.
4.	Төслийн XXI.2.1.54-ийн Өмнөговь аймгийн Номгон сумын соёл, спорт төвийн барилгын төсөвт өртөг “600.0 сая” гэснийг “480.0 сая” гэж өөрчлөх;	Төслийн XXI.2.1.54-ийн Өмнөговь аймгийн Номгон сумын соёл, спорт төвийн барилгын төсөвт өртөг “ 600.0 ” сая төгрөг батлагдсан.
5.	Төслийн хавсралтын XXII.1.61-ийн Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн барилгын “200.0 сая” гэснийг “100.0 сая” гэж өөрчлөх;	Төслийн хавсралтын XXII.1.61-ийн Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийг дэмжих төвийн барилгын “ 200.0 ” сая төгрөг батлагдсан.
6.	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 15 ортой эмнэлгийн барилга “100.0 сая” гэж оруулах;	Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын 15 ортой эмнэлгийн барилга “ 590.0 ” сая төгрөг батлагдсан.
7.	Төслийн хавсралтын XIX.1.29-ийн Баян-Өлгий аймагт шинэ хорооллыг цахилгаан, дулаанаар хангах шугам, сүлжээний өргөтгөлд “300.0 сая” гэж өөрчлөх;	Төслийн хавсралтын XIX.1.29-ийн Баян-Өлгий аймагт шинэ хорооллыг цахилгаан, дулаанаар хангах шугам, сүлжээний өргөтгөлд “ 325.0 ” сая төгрөг батлагдсан.
8.	Баян-Өлгий аймгийн радио өргөн нэвтрүүлгийн станцын “200.0 сая” гэж тусгах;	Баян-Өлгий аймгийн радио өргөн нэвтрүүлгийн станцын “ 550.0 ” сая төгрөг батлагдсан.
	2.Төсөвт өртгийг хассан:	
1.	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Цагаанчулуут/ “300.0 сая” гэж тусгах	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Цагаанчулуут/ 275.0 сая төгрөг гэж хасч баталсан.
2.	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга “300.0 сая” гэж тусгах	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга “275.0 сая” төгрөг гэж хасч баталсан.
3.	Баян-Өлгий аймгийн Өлгий хотын 4-р багийн сургуулийн 2012-2013 онд баригдах биеийн тамирын заалын барилгад төсөвт өртөг “100.0 сая” гэж тусгах	Баян-Өлгий аймгийн Өлгий хотын 4-р багийн сургуулийн 2012-2013 онд баригдах биеийн тамирын заалын барилгад төсөвт өртөг “50.0 сая” төгрөг гэж хасч баталсан.
4.	Завхан аймгийн Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.5 км автозам барих “3,560.0 сая” гэж өөрчлөх	Завхан аймгийн Улиастай-Донойн хөндийн нисэх онгоцны буудал хүртэлх 29.5 км автозам барих “3,310.0 сая” гэж хасч баталсан.
5.	Жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж байгуулах /Булган, Баяннуур/ “40.0 сая” төгрөг	Жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж байгуулах /Булган, Баяннуур/ “35.0 сая” төгрөг гэж хасч баталсан.
	3.Бүхэлд нь хассан:	
1.	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Завхан, Улиастай, Чигэстэй баг/ “200.0 сая”	
2.	Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуй, жижиг, дунд үйлдвэрийн газрын барилга “250.0” сая гэснийг “140.0 сая” гэж өөрчлөх	
3.	Хөвсгөл аймгийн Хатгал сумын соёлын төвийн барилга “”70.0 сая”	
4.	Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын цэцэрлэгийн өргөтгөлийн барилга “40.0 сая”	

УИХ-ын чуулганы 2011 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанд оруулсан төсвийн төсөлд дээрх өөрчилсөн төсөвт өртөг бүхий төсөл, арга хэмжээнүүд тусгагдан 3 дугаар



хэлэлцүүлгийг хийж, 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар төслийг батлан, 2012 оны 12 дугаар сарын 08-ны өдөр ёсчилсноор хуулийн төслийн 1 дүгээр хавсралт “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д 2012 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 1,489,567.8 сая төгрөгөөр батлагдсан байна.

Дээрх жагсаалтад хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ажил нь тодорхой бус, ерөнхий агуулгаар нь нэрлэсэн 87,862.3 сая төгрөгийн төсөвт өртөг, 45,421.3 сая төгрөгийн 2012 онд санхүүжих дүн 46 төсөл, арга хэмжээнүүдийг /хавсралт-1/ тусгасан байна.

ХОЁР. УЛСЫН ИХ ХУРАЛ, ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ, ТҮҮНИЙГ ХАДГАЛАХ, АШИГЛАХ ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг 11 гишүүн, мэргэжил арга зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлэх дэд хэсгийн УИХ-ын Тамгын газрын 3 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр ТБХ-ны даргын 2011 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор баталжээ.

Тус Ажлын хэсгийн хуралдааныг 2011 оны 11 дүгээр сарын 17, 20-нд 2 удаа хийсэн талаар хуулийн товч танилцуулгад тэмдэглэсэн хэдий ч УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлд тус Ажлын хэсгийг 5 удаа хуралдсан тухай зөрүүтэй мэдээлэл тусгагдсан байх бөгөөд тухайн хуралдаануудын тэмдэглэл, холбогдох материалуудыг хуулийн хувийн хэрэгт хавсаргаагүй байгаа нь МУИХЧХДТ хуулийн 54 дугаар зүйлийн 54.2⁸ дахь хэсэгт нийцэхгүй байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх заалтад “Байнгын хороо хууль тогтоомжид нийцсэн дүрэмтэй байх бөгөөд түүнийг хуралдаанаараа батална” гэснийг хэрэгжүүлээгүйгээс дээрх Ажлын хэсгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн батлах үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэхээр томилогдсон дэд хэсгийн болон УИХ-ын Тамгын газрын зарим албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийн хэрэгжилт хангалтгүй /хавсралт-2/ хуралдааны үе шатуудад холбогдох хяналт тавьж ажиллаагүйгээс хуулийн хувийн хэргийн архивын баримт бичгийн бүрдэл дутуу, Баримт бичиг боловсруулах, албан хэрэг хөтлөлтийн стандарт, шаардлага хангагдаагүй байна.

Тухайлбал, Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн хувийн хэрэгт Байнгын хороод болон Төсвийн зарлагын хяналтын дэд хорооноос ТБХ-нд хүргүүлсэн хоёр дахь хэлэлцүүлгийн зөвхөн санал дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёолол архивлагдсан бөгөөд ирүүлсэн саналуудын дагуу хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх үндэслэл болон санхүүжилтийн эх

⁸ 54.2.Хуралдааны тэмдэглэлд дараахь баримт бичгийг хавсарган хадгална: 54.2.4.ажлын хэсгээс Байнгын, дэд, түр хороонд, Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс нэгдсэн хуралдаанд оруулсан санал, дүгнэлт, санал хураалгах томъёоллын төсөл;



үүсвэрийн тооцоо судалгаа тодорхойгүй байгаа нь МУИХЧХДТ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2⁹ дахь заалтад нийцэхгүй байна.

Тус хуулийн товч тайланд “Монгол Ардын Намын бүлгийн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэж, хөрөнгө оруулалтын 54, зардал шилжүүлэх 33 зарчмын зөрүүтэй санал гарч дэмжигдсэн бөгөөд эдгээр саналыг албан бичгээр ирүүлснийг хувийн хэрэгт хавсаргасан болно. Ардчилсан намын бүлгийн хуралдаанаар зарчмын зөрүүтэй 21 санал гарсан байна. Ардчилсан намын бүлгийн саналыг албан бичгээр өгөхийг удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй” талаар тусгасан байна.

МАН-ын бүлгээс 2011 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 69 тоот албан бичгээр УИХ-ын Тамгын газрын Эрх зүй, хууль, тогтоомжийн хэлтэст ирүүлсэн хөрөнгө оруулалтын зардлыг шилжүүлэх саналууд нь 2012 оны төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад тусгагдан батлагдсан хэдий ч бүлгийн хуралдааны тэмдэглэл, холбогдох тооцоо судалгааны материал, ТБХ-ны хоёр дахь хэлэлцүүлэгт өгсөн бүлгүүдийн нэгдсэн санал, дүгнэлт болон хөрөнгө оруулалтын зардлыг нэмэгдүүлэх жагсаалт, холбогдох тооцоо судалгааны материал хуулийн хувийн хэрэгт архивлагдаагүй нь МУИХЧХДТ хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1¹⁰ дэх хэсэгт нийцэхгүй байна.

Тухайн үед УИХ, түүний Тамгын газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд МУИХ-ын Тамгын Газрын ЕНБД-ын 2002 оны 293 дугаар захирамжаар баталсан “Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын хуралдааны явцын тэмдэглэл хөтлөх, соронзон бичлэг хийх, CD-д буулгах, түүнийг хадгалах, ашиглах журам”, мөн 2003 оны 232 дугаар захирамжаар баталсан “Монгол Улсын Их Хурал түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар”, “Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын архивын ажлын заавар”-уудыг мөрдөн ажилладаг байсан бөгөөд эдгээр заавруудын зарим заалтууд нь төрийн албан хэрэг хөтлөлтийн нийтлэг стандарт, шаардлагад нийцээгүй байна. Тухайлбал:

- “Монгол Улсын Их Хурал түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар”-ын 2.9-д зөвхөн А4, А5 хэвлэмэл хуудасны огноог бичих талаар тусгасан нь “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”-ын 2.3.3¹¹, “Баримт бичгийн MNS 5141:2002 стандарт”-ын 6.7¹² заалтуудад нийцээгүй байна.
- “Монгол Улсын Их Хурал түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар”-ын 2.29-т “Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэгтгэн бичиж уг нэгтгэсэн томъёоллын эцэст Тамгын газар гэж бичнэ” гэж заасан нь “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”-ын 2.3.17¹³, “Баримт бичгийн MNS 5141:2002 стандарт”-ын 6.18¹⁴ заалтуудад нийцээгүй байна.
- Дээрх журмуудад компьютерийн санамжид байх мэдээллийг эрж хайх тэмдэглэгээний талаар зохицуулалт тусгаагүй нь “Төрийн албан хэрэг хөтлөлтийн заавар”-ын 2.5.7¹⁵, “Баримт бичгийн MNS 5141:2002 стандарт”-ын 6.27¹⁶ заалтуудад нийцээгүй байна.

⁹ 54.2. Хуралдааны тэмдэглэлд дараахь баримт бичгийг хавсарган хадгална: 54.2.3.хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд, ажлын хэсэг, бусад Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгээс холбогдох Байнгын хороонд бичгээр ирүүлсэн саналын томъёолол, тэдгээрийн үндэслэл, тооцоо, судалгааг тайлбарласан баримт бичиг;

¹⁰ 54.1 Нэгдсэн болон Байнгын, дэд, түр хороо, ажлын хэсэг, нам, эвслийн бүлгийн хуралдааны явцыг бичгээр болон соронзон хальсанд нэгэн зэрэг, шаардлагатай бол дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан тэмдэглэж /цаашид “хуралдааны тэмдэглэл” гэх/ хадгална.

¹¹ 2.3.3 Баримт бичгийн огноог араб тоогоор он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.

¹² 6.7 Огноо нь баримт бичгийг зохиож үйлдсэн, хэлэлцэж баталсан, түүнд албан тушаалтан гарын үсэг зурсан он, сар, өдрийг илэрхийлнэ.

¹³ Төлөвлөгөө, тайлан, удирдамж, танилцуулга зэрэг мэдээлэл-лавлагааны шинж чанартай баримт бичигт зохион байгуулалтын нэгжийн болон албан тушаалын нэрээ зааж, боловсруулсан ажилтан гарын үсэг зурна.

¹⁴ Зохион байгуулалт, мэдээлэл-лавлагааны зарим нэр төрлийн баримт бичигт боловсруулсан ажилтан гарын үсэг зурна.

¹⁵ 2.5.7. Компьютерийн санамжид баримт бичгийг эмх цэгцтэй хадгалах, ашиглах талаар дараах журмыг баримтална.

¹⁶ 6.27 Баримт бичгийн эхний хуудасны баруун доод хэсэгт хадгалсан файлын нэрийг бичнэ.



1.3.4. В. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ ХООРОНД ТӨСӨВ ЗАРЦУУЛАХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ ТАЛААР ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН НАРИЙВЧИЛСАН ЗОХИЦУУЛАЛТГҮЙ БАЙЖЭЭ.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хууль батлагдан гарах үед Монгол Улсын нэгдсэн төсвийн тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан бөгөөд ТБУСТ хуульд ТЕЗ хооронд эрх шилжих тухай нарийвчилсан зохицуулалтгүй, тус хуулийн 15 дугаар зүйлийн 15.4¹⁷ дэх хэсэгт ерөнхий байдлаар тусгагдсан байна.

Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар 2012 онд санхүүжүүлэх нийт төсөвт өртөг 1,489,567.8 сая төгрөг бүхий “Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг баталсан бөгөөд Төсвийн ерөнхийлөн захирагчид улсын төсвийг зарцуулах зарим эрхээ аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлсэн нь холбогдох эрх зүйн акттай нийцэхгүй байна. Тухайлбал,

- ✚ ЗТБХБ-ын сайдын 2011 оны 352 дугаар тушаалаар Аймаг, нийслэлийн Засаг даргатай бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний үндсэн дээр эрх шилжүүлж, гүйцэтгүүлэх Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг баталсан байна.
- ✚ Дээрх тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай ЗТБХБ-ын сайдын 2012 оны 46 дугаар тушаалыг НЗД-тай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээний хавсралтад тооцон “СХД-ийг бүсчлэн хөгжүүлэх хөтөлбөр” 1,820.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий төсөл арга хэмжээний эрхийг шилжүүлсэн нь ЗТБХБ-ын сайд болон НЗД бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн хооронд байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт санхүүжилтийн гэрээний 8 дугаар зүйлийн 8.3¹⁸ дахь заалттай нийцэхгүй байна.

Дээрх төсөв зарцуулах эрхийг шилжүүлэхдээ НЗД 2011 оны 12 дугаар сард ТБУСТ хуулийн 51.1.8¹⁹-д заасны дагуу “2012 оны бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ”-г ЗТБХБ-ын сайд, БСШУ-ны сайд, Эрүүл мэндийн сайд нартай тус тус байгуулсан бөгөөд эдгээр гэрээнүүдийн хавсралтаар ТЕЗ нараас НЗД-д эрх шилжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт батлагдаж, ТЕЗ нарын “Эрх шилжүүлэх тухай” тушаал, шийдвэрүүд гарсан байна. Тухайлбал:

- ✚ Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны “Аймаг, нийслэлд эрх шилжүүлэх тухай” 32 дугаар тушаал;
- ✚ Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 86 дугаар тушаал;
- ✚ Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны “Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарь батлах тухай” 198 дугаар тушаал;
- ✚ Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын сайдын 2011 оны “Жагсаалт батлах тухай” 352 дугаар тушаал;
- ✚ Зам, Тээвэр, Барилга, Хот байгуулалтын сайдын 2012 оны “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар тушаал;

¹⁷ 15.4 Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 15.3-д заасан үүргийг ерөнхий менежертэй байгуулах үр дүнгийн гэрээнд ерөнхий менежерийн нийлүүлэх бүтээгдэхүүний хэлбэрээр тусган өөрийн нэрийн өмнөөс гүйцэтгүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

¹⁸ 8.3 Гэрээнд тусгагдаагүй хөрөнгө, оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцөж, Санхүү эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулсны үндсэн дээр нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно.

¹⁹ 51.1.8 Улсын төсвөөс санхүүжүүлэх бүтээгдэхүүнийг нийлүүлэх талаар аймаг нийслэлийн Засаг дарга тухайн асуудлыг эрхэлсэн Төсвийн ерөнхийлөн захирагчтай, бусад шатны Засаг дарга дээд шатны Засаг даргатай гэрээ байгуулах



- ✚ Монгол Улсын эрүүл мэндийн сайдын 2012 оны “Эрх шилжүүлэн ажил гүйцэтгүүлэх тухай” 254 дүгээр тушаал;
- ✚ НЗД-ын 2012 оны “Эрх шилжүүлэх тухай” А/519 дүгээр захирамж;
- ✚ НЗД-ын 2012 оны “Эрх шилжүүлэх тухай” А/530 дугаар захирамж.

Гэвч дээрх тушаал, шийдвэрүүдийг гаргахдаа тухайн байгууллага албан тушаалтны захиргааны акт гаргах эрх хэмжээнд хамаарахгүй хууль тогтоомжийн заалтуудыг үндэслэл болгосон нь “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн /2002/ 9 дүгээр зүйлийн 9.1.3²⁰, 9.1.7²¹ дахь заалтуудад нийцэхгүй байна. Жишээг хүснэгтэд харуулав.

- | | |
|---|--|
| ✚ | Эрүүл мэндийн сайдын 2012 оны 254 дүгээр тушаал “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 45 дугаар зүйл, 46 дугаар зүйлийн 46.3 ²² дахь заалтыг, |
| ✚ | Зам, Тээвэр, Барилга, Хот, Байгуулалтын сайдын 2011 оны 352 дугаар тушаал “Монгол Улсын засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг |
| ✚ | Зам, Тээвэр, Барилга, Хот, Байгуулалтын сайдын 2012 оны 46 дугаар тушаал “Монгол Улсын засгийн газрын тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь ²³ заалтыг, |
| ✚ | НЗД-ын 2012 оны А/519 дугаар захирамж “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 46 дугаар зүйлийг 46.3 дахь хэсгийг, |
| ✚ | НЗД-ын 2012 оны А/530 дугаар захирамж “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 46 дугаар зүйлийг 46.3 дахь хэсэг зэрэг байна. |

²⁰ 9.1.3 Захиргааны акт гаргах эрх хэмжээгүй захиргааны байгууллага, албан тушаалтан гаргасан;

²¹ 9.1.7 захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй;

²² 46.3 Энэ хуулийн 46.2-т заасан захиалагчийг төлөөлөх эрх бүхий этгээд энэ хуулиар өөрт олгогдсон эрхийг холбогдох албан тушаалтанд шилжүүлж болох боловч ийнхүү эрхээ шилжүүлэх нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

²³ 12.2 Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 12.1-д заасан зарим эрхээ ерөнхий менежер бичгээр шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй



ДҮГНЭЛТ

1. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ-ын ТБХ болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, санал хураалт явуулан, батлахдаа холбогдох хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлээгүй, МУИХТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, МУИХЧХДТ хуулийн 25 дугаар зүйлийн 25.9.2, 25.9.3 дахь заалтууд, 25.13 дахь хэсгийг зөрчсөн байна
2. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёр болон гуравдахь хэлэлцүүлгийг УИХ-ын ТБХ-ны хуралдаанаар хэлэлцэж, гарсан санал, дүгнэлтийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах хувилбартай тулган шалгах, хяналт тавих үйл явц, баримтжуулалтыг журамлан зохицуулаагүйгээс ТБХ-ны хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээс дэмжигдсэн 206,731.5 сая төгрөгөөр хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх саналын дүнг УИХ-ын нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах зарчмын зөрүүтэй саналын томъёололд 214,181.5 сая төгрөг болгож өөрчилсөн зөрчлийн шалтгаан, холбогдогчийг аудитаар тогтоох боломжгүй байна.
3. Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийн хоёрдахь хэлэлцүүлгээр УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж дэмжигдсэн “Хөрөнгө оруулалтын төслийн нэрийг өөрчлөх болон санхүүжилтийн дүнд зохицуулалт хийх санал”-ыг тус хуулийн төслийн гуравдахь хэлэлцүүлэгт оруулж танилцуулахад УИХ-ын Тамгын газрын холбогдох албан хаагчид ажлын байрны чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйгээс нийт 8 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 3,310.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, 5 төсөл, арга хэмжээний төсөвт өртгийг 355.0 сая төгрөгөөр бууруулсан, бүгд 450.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээ хасагдсан байна.
4. Монгол Улсын 2012 оны төсвийг хэлэлцэн баталсан УИХ-ын ТБХ-ны хуралдаан болон УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэл хөтлөх, хадгалах харилцааг нарийвчлан зохицуулаагүй, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байсан “Монгол Улсын Их Хурал, түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх” заавар нь “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар” болон “Баримт бичгийн MNS 5141:2002” стандартын холбогдох заалтуудыг зөрчсөн байна.
5. ТБХ нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 хэсэгт заасан заалтыг хэрэгжүүлээгүй, дүрмээ батлан гаргаагүй, УИХ-аар хуулийн төслийг хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах Ажлын хэсгийн үүрэг хариуцлага, үйл ажиллагааг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.
6. Хуулийн төслийг хэлэлцэн батлах үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх чиг үүрэгтэй УИХ-ын Тамгын газрын холбогдох албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэн баталсан үйл явцын баримт бүрдэлтэд хяналт тавиагүй байна.
7. Төсвийн Ерөнхийлөн захирагч хооронд төсөвт зарцуулах эрх шилжүүлэх талаар хууль, эрх зүйн нарийвчилсан зохицуулалтгүй байснаас Монгол Улсын 2012 оны Төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр 2012 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-д тусгагдсан зарим төсвийг зарцуулах эрх шилжүүлэх тушаал, шийдвэр гаргахдаа тухайн байгууллага, албан тушаалтны эрх хэмжээнд хамаарахгүй хууль, тогтоомжийн заалтуудыг үндэслэл болгосон байна.



ЗӨВЛӨМЖ

УИХ-ын Төсвийн Байнгын хороонд:

1. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсэгт заасны дагуу ТБХ-ны дүрмийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлан гаргах;
2. УИХ-ын Тамгын газрын Төсвийн шинжилгээний албаны дүрэм, журмыг олон улсын туршлагад нийцүүлэн боловсруулж, тус нэгжийг чиг үүргээ хараат бус, бие даасан байдлаар хэрэгжүүлэх нөхцөл, шаардлагыг бүрдүүлэх;
3. ТБХ-ны хуралдаанаар Монгол Улсын төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийхдээ Төсвийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6 дахь заалтыг хангасан, МУИХЧХДТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.2.3-т заасны дагуу "... ирүүлсэн саналын томьёолол, тэдгээрийн үндэслэл тооцоо, судалгааг тайлбарласан баримт бичиг"-ийг бүрдүүлсэн саналыг хэлэлцэж байх,
4. Төсвийн хоёрдугаар хэлэлцүүлгийн үеэр Байнгын хороо, нам эвслийн бүлэг, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон гишүүдээс хөрөнгө оруулалтын төсвийн зардлын зарчмын зөрүүтэй саналыг багцаар нь хэлэлцүүлэн, шийдвэрлэдэг асуудлыг таслан зогсоож, МУИХЧХДТХ-ийн 25 дугаар зүйлийн 25.9.2 дахь заалт, 25.13 дахь хэсэгт заасны дагуу санал тус бүрээр нэг бүрчлэн хэлэлцэж байх.

Монгол Улсын Их хурлын Тамгын газарт:

1. Монгол Улсын төсвийг 4 үе шаттай хэлэлцэн баталдагтай уялдуулан УИХ, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа холбогдох дүрэм, журмыг боловсронгуй болгож, шинэчлэх, түүнд төсвийг хэлэлцэн батлах үе шат бүрд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байх;
2. "Монгол Улсын Их Хурал түүний Тамгын газрын бичиг хэрэг хөтлөх заавар" болон "Монгол Улсын Их Хурал түүний Тамгын газрын архивын ажлын заавар"-уудыг "Баримт бичгийн MNS 5141:2002" стандарт, "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар", "Төрийн архивын ажлын үндсэн заавар"-уудад нийцүүлэн шинэчлэн боловсруулах;
3. "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ыг МУИХЧХДТ хуулийн 54 дүгээр зүйл болон "Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-т нийцүүлэн боловсруулж, түүнд тавигдах нөхцөл, шаардлагын дагуу Байнгын болон дэд хороод, нам эвслийн бүлэг, холбогдох нэгжүүдээс ирүүлэх баримт, материалд хяналт тавьж, хүлээн авч байх;
4. Хуулийн төслийг хэлэлцэн батлах үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй УИХ-ын Тамгын газрын холбогдох албан хаагчдад хариуцлага тооцох, цаашид зөрчил, дутагдал давтан гарахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх.



Хавсралт - 1

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖИЛ, БАЙРШИЛ ТОДОРХОЙ БУС, ЕРӨНХИЙ АГУУЛГААР НЬ
ТУСГАСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ЖАГСААЛТ**

/сая.төгрөг/

Д/Д	ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭР, ХҮЧИН ЧАДАЛ, БАЙРШИЛ	ЭХЛЭХ, ДУУСАХ ХУГАЦАА	ТӨСӨВТ ӨРТӨГ	2012 ОНД САНХҮҮЖИХ
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД				
XII.3.1.24	Багуудад хүргэх шуудангийн үйлчилгээг сайжруулах	2012	1,000.0	1,000.0
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА				
ХҮ.1.19	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Сүхбаатар, 13 сум, тус бүр 2/	2012	200.0	200.0
ХҮ.1.20	"Монгол гэр" хөтөлбөр хэрэгжүүлэх /Улаанбаатар/	2012	276.0	276.0
ХҮ.1.23	Сумдын тохижилт /Увс/	2012	1,000.0	1,000.0
ХҮ.1.35	Орон нутгийн хөгжлийг дэмжих /Дархан-Уул/	2012	525.0	525.0
ХҮ.1.41	Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл /Төв/	2012	242.8	242.8
ХҮ.1.45	"Хөгжил хөтөлбөр" төсөл /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2012	1,000.0	1,000.0
ХҮ.1.46	Нийслэлийн бүтээн байгуулалт /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2012	2,000.0	2,000.0
ХҮ.1.47	"Хан-Уул хөгжил" хөтөлбөр /Улаанбаатар, Хан-Уул, Багануур, Багахангай дүүрэг/	2012	1,000.0	1,000.0
ХҮ.1.54	"Сонгинохайрхан хөгжил" хөтөлбөр /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	1,100.0	1,100.0
ХҮ.1.55	"Сонгинохайрхан хөгжил" хөтөлбөр-Бүтээн байгуулалт, нийгмийн халамж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	1,000.0	1,000.0
ХҮ.1.56	Дүүргийн тохижилт, үйлчилгээ /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	100.0	100.0
ХҮ.1.58	Багуудын чадавхийг сайжруулах /Дорноговь, Говьсүмбэр/	2012	590.0	590.0
ХҮ.1.59	Орон нутаг, багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Өмнөговь/	2012	623.0	623.0
ХҮ.1.72	"Чингэлтэй хөгжил сан" хөтөлбөр /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2012	285.0	285.0
ХҮ.1.78	Багийн хөгжлийг дэмжих хөтөлбөр /Ховд/	2012	660.0	660.0
ХҮ.1.95	Аймгийн хөгжлийг дэмжих хөрөнгө оруулалт /Хэнтий/	2012	100.0	100.0
САНГИЙН САЙД				
ХҮII.1.1.1	Зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах	2012	2,250.0	2,250.0
ХҮII.1.1.2	Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах	2012	1,012.0	1,012.0
ХҮII.1.1.4	Салбарын хөгжлийг дэмжих хөтөлбөр	2012	1,037.3	1,037.3
ХҮII.1.1.5	Орон нутгийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	2012	3,000.0	3,000.0
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД				
ХҮIII.3.1.6	Ажлын байр бий болгох	2011-2012	1,016.0	59.0
ЭРДЭС, БАЯЛАГ ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД				
XIX.2.29	Гэр хорооллын дулаан хангамжийг сайжруулах	2012	250.0	250.0
ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД				



XX.3.1.50	Ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулах	2012-2013	1,800.0	375.0
XX.3.1.69	Бүтээн байгуулалтад бодит хөрөнгө оруулалтын ажил хийх /Говь-Алтай/	2012	400.0	400.0
XX.3.1.70	Аймгийн бүтээн байгуулалт /Говь-Алтай/	2012	300.0	300.0
XX.3.1.87	Хан-Уул хөгжил хөтөлбөр /Улаанбаатар, Хан-Уул, Багануур, Багахангай дүүрэг/	2012	1,000.0	1,000.0
XX.3.1.109	Тохилгог орчин хөтөлбөр /Орхон/	2012	500.0	500.0
XX.3.1.112	Сонгинохайрхан дүүргийг бүсчлэн хөгжүүлэх хөтөлбөр /УБ, Толгойт, Өнөр, Баянхошуу/	2012	1,820.0	1,820.0
XX.3.1.113	Ажлын байр бий болгох, дэд бүтцийг дэмжих /Хөвсгөл/	2012	1,600.0	1,600.0
XX.3.1.115	Баянзүрх хөгжил хөтөлбөр /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2012	1,000.0	1,000.0
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД				
XXI.1.1.76	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдийг дэмжих хөрөнгө оруулалт	2009-2014	7,000.0	1,500.0
XXI.1.1.77	Их, дээд сургуулийг дэмжих хөрөнгө оруулалт	2010-2014	10,000.0	2,000.0
XXI.1.1.222	Цэцэрлэгийн барилга /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2012	500.0	500.0
XXI.1.1.229	Сургууль, цэцэрлэг /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	1,380.0	1,380.0
XXI.1.1.237	Цэцэрлэгийн барилга /Өмнөговь, Сэврэй/	2012	450.0	450.0
XXI.1.1.253	Боловсролын үйлчилгээг дэмжих хөтөлбөр /Ховд/	2012	210.0	210.0
XXI.2.1.70	"Баянгол хөгжил хөтөлбөр" /Улаанбаатар/	2012	2,000.0	2,000.0
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД				
XXII.1.103	Эрүүл мэндийн хөтөлбөр /Улаанбаатар, Чингэлтэй дүүрэг/	2012	1,600.0	1,600.0
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД				
XXIII.1.9	"Гэр" хөтөлбөр /Архангай/	2012	271.2	271.2
	"Гэр" хөтөлбөр /Сүхбаатар/	2012	200.0	200.0
XXIII.1.11	"Гэр хөтөлбөр" /Дорнод/	2012	20.0	20.0
XXIII.1.12	Иргэдийг гэржүүлэх /Увс/	2012	360.0	360.0
XXIII.1.39	Бүтээн байгуулалт, тохижилт, нийгмийн халамж /Улаанбаатар, Сонгинохайрхан дүүрэг/	2012	2,000.0	2,000.0
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД				
XXIV.1.2	Хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах	2011-2015	26,584.0	4,000.0
XXIV.1.3	Услалтын системийг сэргээн засварлах, шинээр барих	2012-2013	6,600.0	2,625.0



МОНГОЛ УЛСЫН 2012 ОНЫ ТӨСВИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ҮЙЛ ЯВЦАД АЖЛЫН БАЙРНЫ ЧИГ ҮҮРГЭЭ БҮРЭН ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙ УИХ-ЫН ТАМГЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН АЖЛЫН БАЙРНЫ ЖАГСААЛТ

№	АЖЛЫН БАЙРНЫ НЭР	АЖЛЫН БАЙРНЫ ТОДОРХОЙЛОЛТОД ЗААСАН ЧИГ ҮҮРЭГ
1.	Байнгын хорооны ажлын албаны дарга	УИХ-д өргөн мэдүүлэгдсэн төслийг Байнгын /дэд, түр/ хорооны болон УИХ-ын нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг ажлын албаны бүх ажилтнуудыг оролцуулан бүрэн хангах Байнгын /дэд, түр/ хороодын ажлын албаны ажилтнуудын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах Тухайн байнгын хороогоор хэлэлцэх өргөн мэдүүлэгдсэн бүх төслийн талаар ажлын албаны зөвлөхийн бэлтгэсэн дүгнэлтийг судалж нэгтгэх Хэлэлцэж байгаа асуудлаархи Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэрхэн бэлтгэж байгааг хянаж, зөвлөгөө өгөх
2.	Байнгын хорооны зөвлөх	3.1. Тухайн байнгын /дэд/ хороогоор хэлэлцэх өргөн мэдүүлэгдсэн бүх төслийг судлан Хорооны эрхлэх асуудлын хүрээ, салбарын бодлогын талаас нь хянаж дараахь дүгнэлтийг бичгээр гарган Байнгын хорооны болон Ажлын албаны даргад танилцуулах: "...3.1.2. уг төсөл Үндсэн хууль болон бусад ямар хуулийн холбогдох ямар заалттай хэрхэн зөрчилдсөн; 3.1.3. уг төсөл дотроо зөрчилтэй заалт агуулсан эсэх" Байнгын хорооны тогтоол, шийдвэрийн төслийг референт боловсруулсныг хянаж, албажуулах Хэлэлцэж байгаа асуудлаархи Байнгын хорооны санал, дүгнэлтийг референт хэрхэн бэлтгэж байгаад зөвлөгөө өгөх
3.	Байнгын хорооны ажлын албаны ахлах референт	3.1 Төсвийн тухай хуулийн төслийг хянаж, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай бол тооцоо, судалгаанд үндэслэсэн санал гаргах 3.4 Төсвийн тухай хуулийн төслийн талаар Байнгын хороодоос гаргах санал, дүгнэлтийг боловсруулахад референтэд зөвлөгөө өгөх 3.5 Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын гишүүд, Байнгын, дэд хороод, намын бүлгүүдээс гаргасан саналуудыг төсөлд хэрхэн тусгасан байдалд хяналт тавих
4.	Байнгын хорооны ажлын албаны референт	Байнгын (дэд) хороог хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэн тус хорооны хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээг авах Байнгын (дэд) хорооноос хууль тогтоолын төсөл хэлэлцэх болон хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд мэргэжлийн туслалцаа үзүүлэх
5.	Байнгын хорооны шинжээч	2.3 Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг зохих стандартын дагуу хөтлөх, ажлын 2 өдөрт багтаан компьютерт шивж хэлбэржүүлэн ажлын хэсгийн ахлагчид танилцуулан албажуулж, албан ажлын хэрэгцээнд бэлэн болгох 2.6 Батлагдсан хууль тогтоомжийн хувийн хэргийг Тамгын газрын архивын ажлын зааврын (2003 оны 232 дугаар захирамжаар батлагдсан) дагуу бүрдүүлэн Ерөнхийлөгчийн хоригийн хугацаа дууссан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор архивт өгөх
6.	Байнгын хорооны нарийн бичгийн дарга	Байнгын хорооны тогтоол, төлөвлөгөө, тайлан, хуралдааны тэмдэглэл, албан бичгүүд, Байнгын хорооноос зохион байгуулсан хяналт шалгалтын ажлын материалыг бүрдүүлэн цэгцэлж, архивт хүлээлгэн өгөх
7.	Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн дарга	Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэх үе шатанд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангаж хяналт тавих УИХ-д өргөн мэдүүлэх хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийн бүрдлийг хянах
8.	Эрх зүй, хууль тогтоомжийн	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэх үе шатанд эхийг нь хариуцан ажиллаж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх



	хэлтсийн зөвлөх	ахлах	УИХ-аар хэлэлцэх төслийн талаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа талаар хууль зүйн дүгнэлт гаргаж холбогдох Байнгын хороонд өгөх
			Төслийн талаархи зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хууль тогтоомж, хууль зүйн нэр томъёо, техникийн шаардлагад нийцүүлэн томъёолон бэлтгэх, нэгтгэх
			Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн саналыг төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг болон эцсийн хэлэцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх
9.	Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн зөвлөх		Хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцэх үе шатанд эхийг нь хариуцан ажиллаж мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх
			УИХ-аар хэлэлцэх төслийн талаар Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа талаар хууль зүйн дүгнэлт гаргаж холбогдох Байнгын хороонд өгөх
			Төслийн талаархи зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хууль тогтоомж, хууль зүйн нэр томъёо, техникийн шаардлагад нийцүүлэн томъёолон бэлтгэх, нэгтгэх
			Анхны хэлэлцүүлгээр шийдвэрлэсэн саналыг төсөлд нэмж тусган төслийн эцсийн хувилбарыг болон эцсийн хэлэцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх
10.	Эрх зүй, хууль тогтоомжийн хэлсийн ахлах зөвлөх-редактор, Эрх зүй, хууль тогтоомжийн хэлтсийн зөвлөх-редактор		УИХ-д өргөн мэдүүлэх төсөлд хавсаргавал зохих бичиг баримт бүрэн хавсаргагдсан эсэхийг хянаж, бүрдлийг хангуулах
			Төсөл холбогдох бусад бичиг баримт нь албан хэргийг хөтлөх нийтлэг шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах
			Төслийн эхийг хариуцан ажиллаж байгаа зөвлөхтэй хамтран ажиллах, хуулийн техник, нэр томъёоны асуудлаар аргачлал, зөвлөгөө өгөх
			УИХ-ын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар шийдэгдсэн зарчмын зөрүүтэй санал бүрэн туссан эсэхийг тулган хянах ажлын зохион байгуулах
11.	Захиргаа боловсон хүчний хэлтсийн архивын эрхлэгч		Тамгын газрын ажилтнууд, УИХ-ын гишүүдийн туслахуудад архивын талаар мэдлэг олгох, арга зүйн туслалцаа үзүүлэх
			Тамгын газрын хэлтэс, албадуудаас архивт баримт бичгийг шилжүүлж авах, хуваарь гаргах, хяналт тавих, мэдээ гаргах



Холбогдох байгууллагын санал:


**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР**
14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
http://www.parliament.mn

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2017 08 08 № 14/1396
танай _____-ны № _____-т

Хариу өгөх тухай

“Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан зарим үйл ажиллагаа болон тус хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох төсвийг зарцуулах эрх олгосон байдал”-д хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлд санал авахаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн 1238 дугаар албан бичгээр ирүүлсэн тайлангийн төсөлтэй танилцлаа.

Дээрх нийцлийн аудитын тайланд тусгайлан саналгүйг үүгээр мэдэгдье.

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ц.ЦОЛМОН


0000002330



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ



2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар БН-02

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын 2012 оны төсвийн тухай хуулийг хэлэлцэн баталсан зарим үйл ажиллагаа болон тус хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний холбогдох төсвийг зарцуулах эрх олгосон байдал”-д хийсэн нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Авилгатай тэмцэх газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний Аудитын газарт ирүүлэхийг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо дарга /Ч.Хүрэлбаатар/, Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга /Ц.Цолмон/ нарт зөвлөсүгэй.

4. Аудитын зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /М.Давааням/-т даалгасугай.

5. Аудитын тайланг батлагдсан өдрөөс хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэж өгөхийг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор /М.Давааням/-т, энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын менежер, байгууллагын нууцын ажилтан /З.Болд/-д тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

070875